

14 МЕССИА: БОЛГООМЖТОЙ БАЙГТУН

14.1 Үг энэ дэлхийд ирсэн

¹Эхэнд Үг байсан, Үг Бурхантай хамт байсан ба Үг нь Бурхан байсан. ²Тэр эхэнд Бурхантай хамт байсан. ³Бүх юм Түүгээр бий болсон. Бий болсон юмсаас Түүнгүйгээр бий болсон юмс нэг ч байхгүй. ⁴Түүнд амь байсан бөгөөд амь нь хүмүүсийн гэрэл байв.

⁵Гэрэл харанхуйг гийгүүлэхэд, харанхуй түүнийг дийлсэнгүй. ⁶Бурханаас илгээгдсэн нэгэн хүн байсан ба нэр нь Иохан юм. ⁷Иохан гэрлийн тухай гэрчилж, бүгдийг өөрөөрөө дамжуулан итгүүлэхийн тулд гэрчлэл хийхээр иржээ. ⁸Тэр бол өнөөх гэрэл байсангүй, харин гэрлийн тухай гэрчлэхээр ирсэн ажээ.

⁹Ертөнцөд ирэн хүн бүрийг гэгээрүүлдэг жинхэнэ гэрэл байв. ¹⁰Тэр ертөнцөд байсан. Ертөнц Түүгээр бий болсон атал, ертөнц Түүнийг таньсангүй. ¹¹Тэр өөрийнхөндөө ирсэн боловч, өөрийнхөн нь Түүнийг хүлээн авсангүй. ¹²Харин

Өөрийг нь хүлээн авсан болгонд, Өөрийнх нь нэрэнд итгэдэг хүмүүст Бурханы хүүхэд болох эрхийг Тэр өгөв. ¹³Тэд цусаар биш, махан биеийн хүслээр ч биш, хүний хүслээр ч биш, харин Бурханаар төрөгсөд билээ. ¹⁴Үг нь махан бие болж бидний дунд оршин, бид Түүний алдрыг харцгаасан. Энэ нь Эцэгийн цорын ганц Хүүгийн алдар бөгөөд нигүүлсэл ба үнэнээр дүүрэн байсан юм. (Иохан 1:1-14 АБ 2004)

¹⁶Учир нь Түүн дотор тэнгэр ба газар дахь бүх юмс, үзэгдэх ба үл үзэгдэх юмс, хаан ширээнүүд, эсвэл ноёрхлууд, удирдлагууд, эсвэл эрх мэдлүүд ч бүтээгдсэн. Бүх юмс Түүгээр болон Түүний төлөө бүтээгдсэн байна. ¹⁷Тэр бүх юмсын урьд байна. Бүх юмс Түүний дотор оршин тогтнодог. ¹⁸Тэр мөн бие болох чуулганы тэргүүн мөн. Тэр бол эхлэл мөн, үхэгсдээс анх төрсөн нь мөн. Энэ нь Тэр Өөрөө бүх юмсын тэргүүн болохын тулд юм. ¹⁹Яагаад гэвэл Бурхан Түүний дотор Өөрийн төгс дүүрэн нь оршдогийг болон ²⁰Түүний загалмайн цусаар энх тайвныг тогтоон,

Түүгээр дамжуулан газар дээрх, эсвэл тэнгэр дэх юмсыг, бүх юмсыг Өөртэйгөө эвлэрүүлснийг таалдаг. (Колоссай 1:16-20 АБ 2004)

[] Та нар Бурханы Хүүхдүүд гэж юу болохыг мэдэх үү?

[] Бүх бүтээлийг юу тогтоож байдгийг та мэдэх үү?

14.2 Бүү тангарагла

⁴Би түүнийг урагшлуулна гэж түмэн цэргийн ЭЗЭН тунхаглаад -Энэ нь хулгайчийн гэрт болон Миний нэрээр хуурамч тангараг тавьдаг нэгний гэрт нэвтэрнэ. Уг гэрийн дотор тэр шөнөжин байж, чулуу, яс модтой нь цуг түймэрдэнэ гэв. (Зехариа 5:4 АБ 2004)

³³Эртний хүмүүст “Хуурамчаар бүү тангарагла, харин ЭЗЭНд амласнаа биелүүл” гэж хэлснийг та нар мөн сонссон. ³⁴Харин Би та нарт хэлье. Юугаар ч бүү тангарагла. Тэнгэрээр ч болохгүй, учир нь энэ нь Бурханы сэнтий юм. ³⁵Газраар ч болохгүй, учир нь энэ нь Түүний хөлийн гишгүүр юм. Иерусалимаар ч болохгүй, учир нь энэ бол аугаа их Хааны хот юм. ³⁶Толгойгоороо ч чи тангараглаж болохгүй, учир нь чи ширхэг үсийг ч цагаан юмуу хар болгож үл чадна. ³⁷Харин үг чинь “За, за” эсвэл “Үгүй, үгүй” байг. Эдгээрээс цааших нь муугаас гардаг хэрэг юм. (Матай 5:33-37 АБ 2004)

¹²Харин юуны өмнө, ах дүү нар минь, та нар тэнгэрээр ч, газраар ч, өөр ямар ч андгайгаар бүү тангарагла. Харин та нарын “за” нь за, “үгүй” нь үгүй байг. Ингэснээр та нар шүүлт дор унахгүй юм. (Иаков 5:12 АБ 2004)

[] Та нар Бурханы Хүүхдүүд гэж юу болохыг мэдэх үү?

[] Тангараглах нь Бурханы байр суурийг эзэлж буйг та мэдэх үү?

14.3 Бүү уурла

²¹“Хүн алж болохгүй, хүний амийг хөнөөсөн хэн боловч шийтгүүлбэл зохино” гэж эртний хүмүүст айлдсаныг та нар сонссон. ²²Харин Би та нарт хэлье, ах дүүдээ хилэгнэгч алив

хүн шүүхийн өмнө буруутай. Ах дүүгээ “Хоосон толгой” гэж хэлсэн хэн боловч зөвлөлийн өмнө буруутай. “Мунхаг” гэж хэлсэн хэн боловч галтай тамд орохоор хангалттай буруутгагдах болно. (Матай 5:33-37 АБ 2004)

[] Эзэн хүмүүний зүрхийг шалган хайж байгааг та мэдэх үү?

14.4 Хүлээн зөвшөөрөгддөггүй өргөл

²³Иймээс, хэрэв чи тахилын ширээнд өргөл өргөх гэж байхдаа чиний эсрэг ямар нэг юм ах дүүд чинь байгааг санавал, ²⁴өргөлөө тахилын ширээний өмнө орхиод замаараа буц. Эхлээд ах дүүтэйгээ эвлэр, дараа нь ирж өргөлөө өргө. (Матай 5:-23-24 АБ 2004)

[] Бурхан таны өргөлийг хүлээн авдаг уу?

14.5 Шүүхэд очихоос өмнө эвлэр

²⁵Замд хамт яваа дээрээ арцалдагчтайгаа аль болохоор түргэн сайдах хэрэгтэй. Эс тэгвэл арцалдагч хүн чинь чамайг шүүгчид өгч, шүүгч түшмэдэд хүргэж, чи шоронд хаягдах вий. ²⁶Үнэнээр Би чамд хэлье, чи эцсийн кодрантыг төлтлөө тэндээс гарахгүй. (Матай 5:25-26 АБ 2004)

[] Та шүүх шийдвэрийнхээ талаар ямар нэг шийдвэр гаргасан уу?

14.6 Тэнэг барилгачин бүү бол

²⁴Тиймд эдгээр үгсийг минь сонсоод, үүний дагуу үйлдэгч аливаа хүн хадан дээр байшингаа барьсан мэргэн хүнтэй зүйрлэгдэнэ. ²⁵Бороо орж, үер буун, салхи салхилж, байшинг нүдсэн боловч тэр нь нурсангүй. Учир нь байшин хадан дээр суурилагдсан байв.

²⁶Эдгээр үгсийг минь сонсоод, үүний дагуу үл үйлддэг аливаа хүн элсэн дээр байшингаа барьсан мунхаг хүнтэй зүйрлэгдэнэ. ²⁷Бороо орж, үер буун, салхи салхилж, байшинг нүдсэнд байшин нурав. Эвдрэл нь асар их байлаа гэв.

²⁸Тэгээд Есүсийг үгээ хэлж гүйцмэгц олон түмэн Түүний сургаалыг гайхаж байлаа. ²⁹Тэр хуулийн багш нар шиг нь бус, эрх мэдэлтэй нэгэн шиг тэдэнд зааж байв. (Матай 7:24-29 АБ 2004)

¹³Ард түмнүүд галын төлөө нөр их хөдөлмөрлөн, үндэстнүүд хоосон зүйлийн төлөө эцэж ядрах нь үнэндээ түмэн цэргийн ЭЗЭНээс болж байгаа бус уу? (Хабаккук 2:13 АБ 2004)

¹¹Үзэгтүн, гал ноцоож, бамбаруудаар өөрсдийгөө хүрээлэгч та нар бүгдээрээ галынхаа гэрэлд, ноцоосон бамбаруудынхаа дундуур алхагтун. Үүнийг чи Миний мутраас авна. Чи зовлон шаналал дунд хэвтэнэ. (Исаиа 50:11 АБ 2004)

⁵⁸Түмэн цэргийн ЭЗЭН ингэж айлдаж байна. “Вавилоны өргөн хана хэрэм бүрэн гүйцэд нурж, түүний өндөр дааман хаалганууд шатна. Тиймээс хүмүүс юу ч биш юмны төлөө ажиллан, үндэстнүүд галын төлөө сульдах болно”. (Иеримиа 51:58 АБ 2004)

¹¹Шударга бусаар эд хөрөнгөтэй бологч нь гаргаагүй байж өндөг дардаг ятуутай адил юм. Хижээл насанд нь энэ нь түүнийг орхиж, эцэст нь тэр мунхаг болно”. (Иеримиа 17:11 АБ 2004)

[] Та заадаг зүйлээ ажил хэрэг болгодог уу?

[] Та нар ажил үйлсээ элсэн дээр биш, хадан дээр барьж байна уу?

[] Үндэстнүүд хоосон зүйлийн төлөө дэмий л туйлдаж байгааг та мэдэх үү?

[] Арга ч , амжилт ч биш харин зөвхөн төгсгөл болох Есүс Христ л бүгдийг зөвтгөдөг.

14.7 Зөв газарт баялаг хадгалах

¹⁹Газар дээр өөрсдөдөө эд баялаг бүү хураа. Тэнд хивэн хорхой болоод зэв идэж сүйтгэдэг, хулгайч эвдэж ороод хулгайлан авдаг аж. ²⁰Харин тэнгэрт эд баялгийг өөрсөддөө хураа. Учир нь тэнд хивэн хорхой болоод зэв идэж

сүйтгэдэггүй, хулгайч ч эвдэж ордоггүй, хулгайлдаггүй. ²¹Та нарын эд баялаг хаана байна, зүрх сэтгэл чинь бас тэнд байх болно.

²²Нүд бол биеийн дэнлүү мөн. Хэрэв нүд чинь цэвэр бол бүтэн бие чинь гэрлээр дүүрэн байх болно. ²³Харин нүд чинь муу бол бүтэн бие чинь харанхуйгаар дүүрэн байх болно. Иймд хэрэв чиний доторх гэрэл нь харанхуй байх юм бол, тэрхүү харанхуй нь юутай их вэ!

²⁴Хэн ч хоёр эзэнд үйлчилж чадахгүй. Тэр нэгийг нь үзэн ядаж, нөгөөг нь хайрлах болно. Эсвэл нэгээс нь зуурч, нөгөөг нь зэвүүцнэ. Та нар Бурхан болоод эд баялагт хоёуланд нь зэрэг үйлчилж чадахгүй. (Матай 6:19-24 АБ 2004)

[] Та тэнгэрт эд баялаг хэрхэн нөөцлөхийг мэддэг үү?

[] Бурханд чин үнэнч байх гэж юу гэсэн үг вэ?

[] Бурханы эдгээр дайснуудыг та эргэн тойрондоо байгааг харж байна уу?

[] Та тэдгээрийг хэрхэн таньж мэдэх вэ?

[] Та тэдний нийтлэг төрхийг олж хардаг уу?

Шашны удирдагчид – Тахилч ба садукайчууд

Улс төрийн удирдагчид – Херод ба Ром

Шашны сүсэглэл – Фарисайчууд

Өөрийгөө дорд үздэг – Төрсөн нутгийн хүмүүс

Олон түмний сэтгэл зүй – Олны санал бодлыг дагах

Хөндий байдал – Хотын хүмүүс ажил хэрэгтээ завгүй

Шашингүй сэтгэхүй – Бичээч, хуульч

14.8 Мөнхийн нүгэл

²⁰Есүс гэрт ороход дахиад л бөөн хүн цугларч тэдэнд юм идэх ч завдал өгсөнгүй. ²¹Үүнийг сонсоод хамаатнууд нь Есүсийг авчрахаар явав. Учир нь хүмүүс Түүний тухай-Тэр Өөрийн ухаан мэдрэлээ алджээ гэж ярьж байлаа. ²²Иерусалимаас ирсэн хуулийн багш нар-Тэр Беелзебултэй гээд-Тэр чөтгөрүүдийн захирагчаар чөтгөрүүдийг хөөн зайлуулдаг гэцгээж байлаа.

²³Тэр тэднийг Өөр уруугаа дуудаж сургаалт зүйрлэлээр тэдэнд айлдруун -Сатан Сатаныгаа яаж хөөн зайлуулж чадах билээ? ²⁴Хэрэв хаанчлал дотроо хуваагдвал, тэр хаанчлал нь оршин тогтнож чадахгүй. ²⁵Хэрэв айл гэр дотроо хуваагдвал, тэр айл гэр оршин тогтнох чадваргүй болно. ²⁶Хэрэв Сатан өөрийн эсрэг босон хуваагдвал, тэр оршин тогтнож чадахгүй, харин эцэс нь ирнэ. ²⁷Хүчтэй эрийг эхлээд хүлж байж л гэрийг нь дээрэмдэнэ үү гэхээс гэрт нь шууд ороод эд хөрөнгийг нь дээрэмдэж чадах хүн байхгүй билээ.

²⁸Үнэнээр Би та нарт хэлье. Хүний хөвгүүдийн бүх нүгэл, тэдний ярьсан доромжлол бүхэн уучлагдана. ²⁹Харин Ариун Сүнснийг доромжлогч хэн ч хэзээ ч уучлагдахгүй бөгөөд мөнх нүглийн гэмтэн болно гэв. ³⁰Учир нь тэд-Есүс бузар сүнстэй гэж ярьж байсан юм. (Марк 3:20-30 АБ 2004)

[] Та чөтгөрийн үйлийг юу устгадгийг мэдэх үү?

14.9 Хоёр дахь үхлээс ай

⁸Харин хулчгар, итгэлгүй, жигшүүрт, алуурчид, завхай хүмүүс, мэргэ төлөгчид, шүтээнд мөргөгчид болон бүх худалч хүмүүсийн хувьд, тэдэнд оногдох хувь нь хоёр дахь үхэл буюу хүхэр, галаар шатаж буй нуурт байна гэв. (Илчлэлт 21 :8 АБ 2004)

[] Та хүхэрт нуурт ямар хүмүүст оногдохыг та тодорхойлж чадах уу?

14.10 Зовлонг сорилт

¹²Хайртай хүмүүс минь, та нарыг сорихын тулд дунд чинь ирдэг галт сорилтод ямар нэгэн хачирхалтай юм та нарт

тохиолдсон мэт бүү гайх. ¹³Харин та нар Христийн зовлонгуудыг хуваалцдагтаа баярла. Ингэснээр мөн Христийн алдар илчлэгдэхэд та нар баяр хөөртэйгөөр баярлах юм. ¹⁴Хэрэв та нар Христийн нэрээс болж зүхэгдвэл ерөөлтэй. Учир нь алдрын ба Бурханы Сүнс та нарын дээр оршдог. ¹⁵Та нараас хэн нь ч алуурчин, эсвэл хулгайч, эсвэл хорон мууг үйлдэгч юм уу, эсвэл бусдын хэрэгт хошуу дүрдэг нэгэн мэт бүү зовог. ¹⁶Хэрэв Христийнх гэдгээсээ болж зовдог бол бүү ич. Харин энэхүү нэрээрээ Бурханыг алдаршуул. ¹⁷Яагаад гэвэл шүүлт Бурханы гэр бүлээс эхлэх цаг нь болжээ. Хэрэв энэ нь биднээс эхэлбэл Бурханы сайн мэдээг дагадаггүй хүмүүсийн төгсгөл юу болох вэ? ¹⁸Хэрэв зөвт хүн арай гэж аврагдах юм бол, бурхангүй хүн болон нүгэлтэн яах болж байна? ¹⁹Тиймээс Бурханы хүслийн дагуу зовогсод зөвийг үйлдэхдээ итгэмжит Бүтээгчид сүнсээ даатгаг. (1 Петр 4 :12-19 АБ 2004)

⁷Тийм учраас, ах дүү нар аа, Эзэнийг ирэх хүртэл тэвчээртэй байгтун. Харагтун, тариачин хөрсний үнэт бүтээгдэхүүнийг хүлээдэг. Ингэхдээ тэр эрт ба оройтож орох бороог ортол тэсвэртэйгээр хүлээдэг юм. ⁸Та нар ч бас тэвчээртэй бай. Эзэний ирэх ойртсон тул зүрхээ чангал.

⁹Ах дүү нар аа, та нар өөрсдөө шүүгдчихгүйн тулд бие биеийнхээ эсрэг бүү гомдолло. Харагтун, шүүгч хаалган дээр зогсож байна. ¹⁰Ах дүү нар аа, Эзэний нэрээр ярьж байсан эш үзүүлэгчдийг авч, зовлон ба тэвчээрийн жишээ болгогтун. ¹¹Харагтун, бид тэвчсэн хүмүүсийг ерөөгдсөнд тооцдог. Та нар Иовын тэсвэр тэвчээрийн тухай сонсож, Эзэн эцэст нь юу хийснийг харсан. Яагаад гэвэл Эзэн энэрлээр дүүрэн агаад өршөөнгүй юм. (Иаков 5 :7-11 АБ 2004)

[] Нүглээс биш Есүс Христэд итгэсэн итгэл үнэмшлээс болж зовж шаналж эсвэл доромжлуулж байсан уу?

[] Тэвчээр бол итгэлийн чанарыг ялгадаг гэдгийг та мэдэх үү?

14.11 Тэнгэр бол зөвхөн бат итгэлтэй хүмүүст зориулагдсан

Тэнгэрийн хаанчлал бол зөвхөн Бурханы хүслийн дагуу амьдардаг хүмүүст л зориулагдсан.

Их Эзэний уулан дээр хэн оршин сууж чадах билээ ? Хэн Түүний асар дотор оршин сууж чадах билээ ?

¹ЭЗЭН, Таны асарт хэн оршин суух вэ? Таны ариун ууланд хэн амьдран суух вэ? ²Үнэнчээр явж, зөв шударгыг үйлдэж, Зүрхэндээ үнэнийг өгүүлдэг хүн. ³Тэрээр хэлээрээ гүтгэдэггүй, Өөрийн анд нөхөрт ч муу юм хийдэггүй, Хөршийгөө ч эсэргүүцэн буруутгадаггүй. ⁴Түүний нүдэнд олиггүй хүн жигшигддэг Боловч ЭЗЭНээс эмээгчдийг тэрээр хүндэлдэг юм. Тэр өөрөө хохирсон ч андгайлснаасаа няцдаггүй. ⁵Тэр өөрийн мөнгийг хүүтэй зээлүүлдэггүй, Гэмгүй хүний эсрэг хахууль авдаг ч үгүй. Эдгээрийг үйлдэгч нь хэзээ ч ганхахгүй. (Дуулал 15 :1-5 АБ 2004)

[] Бүтээгч Эзэнийхээ өмнө та эдгээр 11 чанарыг хэрэгжүүлж чадах уу ?

14.12 Тэнгэр: Дахин төрөх ёстой

¹Фарисайчуудын дотор Никодем гэгч хүн байлаа. Тэр иудейчүүдийн удирдагчдын нэгэн байв. ²Тэр хүн Есүс дээр шөнөөр ирээд Түүнд -Рабби, Таныг Бурханаас ирсэн багш гэдгийг бид мэднэ. Учир нь Бурхантай хамт байхгүй л бол, хэн ч Таны үйлддэг тэмдгүүдийг үйлдэж чадахгүй гэв.

³Есүс хариуд нь-Үнэнээр, үнэнээр Би чамд хэлье. Хэн дээрээс эс төрнө, тэр хүн Бурханы хаанчлалыг үзэж чадахгүй гэхэд ⁴Никодем Түүнд -Настай болсон атлаа хүн хэрхэн төрөх билээ? Хүн эхийн хэвлийд хоёр дахиа орж, төрж чадна гэж үү? гэлээ.

⁵Есүс -Үнэнээр, үнэнээр Би чамд хэлье. Хэн ус болон Сүнснээс эс төрнө, тэр хүн Бурханы хаанчлалд орж чадахгүй. ⁶Махан биеэс төрсөн нь махан бие, Сүнснээс төрсөн нь сүнс болой. ⁷“Чи дээрээс төрөх ёстой” гэж Би чамд хэлсэнд бүү гайх. ⁸Салхи дуртай газраараа үлээдэг. Чи дууг нь сонсовч, салхийг хаанаас ирж, хааш оддогийг мэддэггүй. Сүнснээс төрсөн хүн бүр үүнтэй адил байдаг гэж айлдав.

⁹Никодем Түүнээс-Ийм юм яаж байх юм бэ? гэж асуулаа. ¹⁰Есүс -Чи Израилийн багш атлаа үүнийг ойлгохгүй байна гэж үү? ¹¹Үнэнээр, үнэнээр Би чамд хэлье. Бид мэдсэнээ ярьж, үзсэнээ гэрчилж байхад та нар бидний гэрчлэлийг

хүлээн авдаггүй. ¹²Хэрэв Би чамд газрын юмсыг ярихад чи итгэхгүй бол, тэнгэрийн юмсыг Би яривал, чи яаж итгэх юм бэ?

¹³Тэнгэрээс доош бууж ирсэн Хүний Хүүгээс өөр тэнгэрт дээш гарсан хүн нэг ч байхгүй. ¹⁴Мосе цөлд тэр могойг өргөсөн шиг, Хүний Хүү ч бас өргөгдөх ёстой. ¹⁵Энэ нь Түүнд итгэгч хүн бүрийг мөнх амьтай байлгахын тулд билээ.

¹⁶Бурхан ертөнцийг үнэхээр хайрласан тул цорын ганц Хүүгээ өгсөн. Ингэснээр Хүүд итгэгч хэн ч мөхөхгүй, харин мөнх амьтай болох юм. ¹⁷Бурхан Өөрийн Хүүгээ ертөнцийг яллахын тулд биш, харин Түүгээр дамжуулан ертөнцийг аврахын тулд ертөнц уруу илгээсэн билээ.

¹⁸Түүнд итгэдэг хүн яллагдахгүй. Харин үл итгэдэг хүн аль хэдийн ялагдсан. Учир нь тэр хүн Бурханы цорын ганц Хүүгийн нэрэнд итгээгүй юм.

¹⁹Тэрхүү яллалт ийм билээ. Гэрэл ертөнцөд ирэхэд хүмүүсийн үйлс бузар муу учир тэд харанхуйг гэрлээс илүү хайрласан юм. ²⁰Учир нь өөрийнх нь үйлс ил гарчих вий гэж бузрыг үйлдэгч хүн бүр гэрлийг үзэн ядаж, гэрэл уруу гарч ирдэггүй. ²¹Харин үйлс нь Бурханы дотор үйлдэгдсэн гэдгийг ил харуулахын тулд үнэнийг үйлдэгчид гэрэл уруу ирдэг гэлээ. (Иохан 3 :1-21 АБ 2004)

[] Үхлийн дараа хүний бие устах боловч сүнс нь мөнх амьдрах болно гэдэгт та итгэдэг үү?

[] Нигүүлслээрээ Бүтээгч Бурхан Өөрийн цорын ганц хүүгээ илгээсэн гэдэгт болон Тэр та нарын нүглийн төлөө загалмай дээр үхсэн гэдэгт та итгэдэг үү?

14.13 Эдгээр нь Тэнгэрт зориулагдаагүй

¹⁵Гадна талд нь ноход, мэргэ төлөгчид, завхай хүмүүс, алуурчид, шүтээнд мөргөгчид болоод худлыг хайрладаг, үйлддэг бүхэн байна. (Илчлэлт 21 :15 АБ 2004)

[] Та нар энэ хүмүүсийн нийтлэг шинжийг мэдэх үү